




СОЁЛЫН ЯАМ

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ

2024.05.16

*Монгол соёл
Монголын баялаг*

2024 он





СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй улс болно. Монгол хүний оюуны бүтээлийг дэлхийн зах зээлд сурталчлах төсөл хэрэгжүүлнэ..., “Бүтээлч үйлдвэрлэл хөгжлийн бодлогын суурийг тавьж, **бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлнэ**”, “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоно
- “Шинэ сэргэлтийн бодлого”. “Аж үйлдвэрийн сэргэлт” -ийн 3.6. шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал **эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэрийг хөгжүүлэх**”, 4.3.Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ,
- МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР-ийн 2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, **соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн**, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болохыг зорьж, 2.6.3.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн **соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх**, 2.6.3.3.үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, **эдийн засгийн эргэлтэд оруулна.**



ҮНДЭСНИЙ НӨГДМЭЛ
ҮНЭТ ЗҮЙЛ



ХҮНИЙ
ХӨГЖИЛ



АМЬДРАЛЫН ЧАНАР БА
ДУНДАЖ ДАВХАРГА



ЭДИЙН
ЗАСАГ



САЙН
ЗАСАГЛАЛ



НӨГӨӨН
ХӨГЖИЛ



АМАР ТАЙВАН
АЮУЛГҮЙ НИЙГЭМ



БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ



УЛААНБААТАР БА
ДАГУУЛ ХОТ

АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО



СУДАЛГАА, ПРАКТИК ҮНДЭСЛЭЛД ТУЛГУУРЛАСАН БАЙДАЛ:

Соёлын яамнаас хийсэн тайлан, судалгаа:

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн **суурь судалгаа 2021**
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын **тандан судалгааны тайлан**
- **Олон улсын зөвлөх** Том Флемингийн гүйцэтгэсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын судалгаа
- Үндэсний соёлын нэгдмэл үнэт зүйлийн индексийн судалгаа 2022
- Бусад судалгааны материал, тайлан, эрдэм шинжилгээний өгүүллэг, гарын авлага

Ашигласан судалгаа, тайлан:

- **ЮНЕСКО-гийн 2005 оны конвенцын дэлхийн тайлан/Global Report 2018**
- Үндэсний статистик мэдээлэл
- **“Монголын өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь”** НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас 2019 онд гаргасан Монголын хүүхэд, өсвөр үеийнхний амьдралын талаарх тайлан, дүн шинжилгээ
- Европын холбооны гишүүн улсууд, Их Британи, Умард Ирланд Нэгдсэн Вант Улс, БНХАУ, БНСУ, Тайвань гэх зэрэг улсуудын баримталж буй бодлого, хуулиуд

Хэлэлцүүлэг

- 2021, 2022 оны “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум”-д 12 салбар, 90 гаруй чиглэлийн төлөөлөлд танилцуулсан.
- 2022 оны 12 дугаар сарын сараас 2023 оны 1 дүгээр сард салбар тус бүрээр хэлэлцүүлгийг зохион байгуулж, соёлын салбарын эрдэмтэн, судлаач, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн 73, хамтын удирдлагын болон төрийн бус байгууллага, бусад байгууллагын 3000 гаруй хүнд танилцуулсан.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ(СБҮ)

Соёлын бүтээлч үйлдвэрлэл, түүний үйл ажиллагааны үндсэн зорилго нь “Соёл, урлаг, соёлын өвд сүүрилсэн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, түгээх, борлуулах замаар нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх”

ЮНЕСКО, 2005 оны конвенц

ДЭЛХИЙД



Цувралыг бүтээсэн зардал

\$21.4 сая

Борлуулалтын орлого

\$891 сая


БНСУ 1996 ОНД ОЕСД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН СБҮ-ИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ГАРГАСАН.

БНСУ дахь эдийн засгийн дам нөлөө

- Бүхээгтэй машины борлуулалт: **7800% өссөн**
- Dalgona амттаны борлуулалт: **250% өссөн**
- Гол дүрийн жүжигчний Instagram дагагчийн тоо: 400К → **19 сая болж өссөн**


СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

МОНГОЛД




Бүтээлч салбар

- Соёлын бүтээлч үйлдвэрлэл
- Харилцаа, холбоо
- Мэдээллийн технологи
- Биотехнологи
- Эрүүл мэнд, гоо сайхан
- Хоол үйлдвэрлэл
- Чөлөөт цаг өнгөрүүлэх үйл ажиллагаа, түүний төлөвлөлт



ЮНЕСКО – СОЁЛЫН ЭДИЙН ЗАСАГ



“соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэж хүний оюун санаа, авьяас, чадвар, бүтээлч сэтгэлгээний үр дүнд технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх үйл явцыг

 1. СОЁЛЫН ӨВ	 2. УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ	 3. ДҮРСЛЭХ УРЛАГ	 4. ДУУ, ХӨГЖИМ	 5. ТАЙЗНЫ УРЛАГ	 6. КИНО, ДУУ ДҮРСНИЙ УРЛАГ
<p>Биет өвийг хамгаалах, сэргээн засварлах</p> <ul style="list-style-type: none"> Түүх соёлын үл хөдлөх дурсгал Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл (Музейн үзмэр); Археологийн олдвор; <p>Биет бус өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Нүүдлийн соёл; Аман зохиол; Монгол судлал; Хэл шинжлэл, Соёл судлал; Антропологи. 	<ul style="list-style-type: none"> Утга, уран зохиолын бүтээл, орчуулга; Хүүхдийн ном, зохиол; Шүүмж судлал; Хэвлэн нийтлэх үйл ажиллагаа (Publishing); Редакторлах, хэвлэлийн эх бэлтгэх, хувилах, хэвлэх (Printing); Номын худалдаа; Номын сан; Цахим болон аудио ном. 	<ul style="list-style-type: none"> Уран зураг; Баримал; Дижитал арт; Өрөг урлаг (Инстоляц); Үйлдлийн урлаг (Performance Art); (Land Art); Дуу авиан урлаг (Sound Art); Бар урлаг; График урлаг; Гэрэл зураг; Гар урлал, сийлбэр; Урлан, Галерей, Музей. 	<p>Бүх төрөлд:</p> <ul style="list-style-type: none"> Дууны үг, ая зохиогчид, хөгжмийн зохиолчид; Хамтлаг, дуучид; Оркестр, найрал хөгжим; Рекордс болон лабелинг; Дуу, бичлэгийн студи, продакшн; Дуу хөгжмийн бүтээлийг хувиран олшруулах, худалдаалах үйл ажиллагаа, стриминг; Хамтын удирдлагын байгууллага; Концерт, амьд хөгжмийн тоглолт зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> Бүжиг (Орчин үеийн, сонгодог, ардын); Ардын урлагийн театр; Мюзикл; Гэрлийн шоу; Дууны шоу; Хүүхэддэйн театр; Галт наадам; Цирк; Хошин урлаг; Фестиваль. 	<ul style="list-style-type: none"> Арилжааны кино (Mainstream film); Арт хаус кино (Art house film); Баримтат кино; Хүүхэддэйн кино; Киноны студи, продакшн; Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ, кино павильон; Пост продакшн студи; Кино түгээлтийн компаниуд; Кино наадам; Кино театр; Кино сан, видео сан; Кино түгээлтийн сувгууд (Film publishing); Кино урлагийн салбарын мэргэжлийн холбоод, ТББ.
 7. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	 8. ХУВЦАС ЗАГВАР	 9. АРХИТЕКТУР	 10. ДИЗАЙН	 11. ДИЖИТАЛ, КОНТЕНТ, ТОГЛООМ ХӨГЖҮҮЛЭЛТ	 12. МАРКЕТИНГ, БРЭНДИНГ, КОММУНИКАЦИ
<ul style="list-style-type: none"> Телевиз, радио; Сонин, сэтгүүл; Цахим хэвлэл, мэдээлэл; Олон суваг дамжуулах үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> Хувцас, загварын дизайн; Дагалдах хэрэгслийн дизайн; Нэхмэл, сүлжмэл, ноолууран бүтээгдэхүүний дизайн; Материал, технологийн судалгаа; Хувцас, загварын үйлдвэрлэл; Хувцас загварын студи; Загвар өмсөгчдийн сургалт, агентлаг; Загварын шоу, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, экспо; Сүлжээ дэлгүүр, бүтик, цахим худалдааны платформууд. 	<ul style="list-style-type: none"> Үндэсний уламжлалт архитектур дизайн; Хот төлөвлөлт; Ландшафт, орчны төлөвлөлт; Барилга байгууламжийн архитектур төлөвлөлт. 	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэлийн дизайн; Хэвлэлийн дизайн; Сурталчилгааны дизайн; Бүтээгдэхүүн, сав баглаа боодлын дизайн; Хаягжилтын дизайн; Интерьер дизайны төлөвлөлт, шийдэл, засал чимэглэл; Аппликэйшн, цахим хуудасны дизайн (Web design);График дизайн (Graphic design). 	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийн мэдрэмжийн дизайн (UX); Хэрэглэгчийн интерфэйс (UI); Цахим тоглоом хөгжүүлэлт (Game Development); AR, VR, AI контентууд. 	<ul style="list-style-type: none"> Маркетингийн судалгааны агентлаг; Брэндинг, PR, коммуникацийн агентлаг; Зар сурталчилгааны агентлагууд; Sales house.

Зах зээл



ЭХ БҮТЭЭЛ

- Оюуны дархлааг бий болгодог
- Завсрын нөөц шингэдэггүй нэмүү өртөг багатайгаар үнэ цэн бүтээдэг
- Ажиллах хүчний оролцоо өндөр
- Улс орныг сурталчилдаг
- Соёлын олон талт байдлыг таниулдаг ач холбогдолтой

СОЁЛ,
СОЁЛЫН ӨВ,
АВЪЯАС

БҮТЭЭЛЧ БАЙДАЛ

ТЕХНОЛОГИ

ОЮУНЫ ӨМЧ




Эдийн засгийн бие даасан салбар болох
(Одоогийн байдлаар ДНБ-д 1.4% эзэлж буй бол 2027 он гэхэд 4% болж нэмэгдэнэ)

Нийгмийн үр нөлөө: Үндэсний агуулгатай Монгол соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, Үндэсний нэгдмэл үнэт зүйл бэхжүүлэх

Соёлын аялал жуулчлал
Аялал жуулчлалыг дэмжсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОСИСТЕМ



➡ Нийгмийн инновацийн цикл
➡ Арилжааны цикл

Эх үүсвэр: Ж.Эрхэмтөгс, ЮНЕСКО, БҮИТ, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019

6 бүлэг, 30 зүйлтэй

I. БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

(Хуулийн зорилт, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, Хуулийн үйлчлэх хүрээ, Хуулийн нэр томъёоны тодорхойлолт, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилго, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баримтлах зарчим, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээ, чиглэл)

II. БҮЛЭГ

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТӨРӨӨС ДЭМЖИХ (Үндэсний соёлын агуулгыг дэмжих, Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэг, **Технологийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих**, Судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг, Оюуны өмчийн хамгаалалтын дэмжлэг, **Төсөв, хөрөнгө оруулалт**, санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг, Мэдээлэл солилцох, олон улсын зах зээлд нэвтрэхэд үзүүлэх дэмжлэг)

III. БҮЛЭГ

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА (Төр, хувийн хэвшлийн нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийг нэмэгдүүлэх, ашиглуулах, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг **кластераар** хөгжүүлэх, Соёлын өвийг сурталчлах, үндэсний үнэт зүйлийг илэрхийлэн таниулах орчин бүрдүүлэх)

IV. БҮЛЭГ

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ (Бүртгэл, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг)

V. БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ (Засгийн газрын бүрэн эрх, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх, Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх, Аймаг, нийслэлийн соёл урлагийн газрын бүрэн эрх)

VI. БҮЛЭГ

БУСАД (Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дахь тайлагнал, ил тод байдал, Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, Хууль хүчин төгөлдөр болох)



Хуулийн зорилт: Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. (1 дүгээр зүйл)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилго:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилго нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэгдэнэ. (5.1 дэх хэсэг)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баримтлах зарчим:

нийгмийн түншлэл, иргэдийн оролцоог дэмжсэн байх, орон нутгийн өвөрмөц онцлог, чадавхид үндэслэсэн, өрсөлдөх чадварыг дэмжсэн байх, байгаль орчинд ээлтэй байх, судалгаа, шинжилгээнд үндэслэн, дэвшилтэт технологи, инновацад тулгуурласан байх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, эдийн засгийн үр ашигтай байх, салбар хоорондын уялдааг хангах, ил тод, нээлттэй, тэгш, хүртээмжтэй байх (6 дугаар зүйл)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээ:


Соёлын тухай хуулийн 9.1-д заасан үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно (7.2.1.хөгжим, тайзны урлаг, гүйцэтгэн тоглох урлагтай холбоотой бусад салбарууд; 7.2.2.кино, дэлгэцийн урлаг, дижитал контент, тоглоом хөгжүүлэлттэй холбоотой салбарууд; 7.2.3.дурслэх урлаг, архитектур, дизайн, хувцас загвар, гар урлалтай холбоотой салбарууд; 7.2.4.утга зохиол, ном, хэвлэлтэй холбоотой салбарууд; 7.2.5.соёлын өв, соёлын үнэт зүйлтэй холбоотой болон бүтээлч орон зай, чөлөөт цагийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой салбарууд) (7 зүйл)

Үндсэн болон тэргүүлэх чиглэл:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндсэн болон тэргүүлэх чиглэлийг тогтооно. (7 зүйл)



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТӨРӨӨС ДЭМЖИХ /II БҮЛЭГ/





- ❖ Соёлын агуулга бий болгох, бүтээхэд төсөл шалгаруулах замаар дэмжлэг үзүүлэх,
- ❖ Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх
 - Авьяас, бүтээлч байдалд тулгуурладаг – **авьяасыг дэмжих, бэхжүүлэх**, авьяастанд арга зам, шинэ сувгуудыг нээн өгөх
 - Бүхий л насны болон бусад олон салбарын ажиллах хүчийг дэмждэг салбар
 - **15-29 насныхан** хамгийн их ажилладаг (UNESCO, 2017);
 - Тал хувь нь **эмэгтэйчүүд** (UNESCO, 2017)
- Жижиг бизнес эрхлэгчид аль эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэгч, чөлөөт уран бүтээлч



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ШАТАНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ



Технологийн судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэхэд шаардлагатай технологийг шинээр нэвтрүүлэх, дамжуулах, хөгжүүлэхэд өндөр бүтээмжтэй, салбарын инновацийн чадавхыг нэмэгдүүлэх эсхүл олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх байдлыг харгалзан үзүүлнэ.

Татварын дэмжлэг

Татварын дэмжлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлнэ.



Судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтийн төсөл хөтөлбөрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд тэргүүн ээлжид хамруулах;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтийн төсөл хөтөлбөрт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулах үндэсний болон олон улсын стандартыг боловсруулан батлуулахад дэмжлэг үзүүлэх;


ТҮГЭЭЛТИЙН ШАТАНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ ОЮУНЫ ӨМЧИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ ЭКО СИСТЕМ

Оюуны өмч, зохиогчийн эрхийн бүртгэл мэдээллийн зохицуулалт

Эдийн засгийн эргэлтэнд оруулах зохицуулалт

ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

СБҮ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ




ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Оюуны өмчийг хэрэглээнд оруулах зохицуулалт

- Бүртгэл
- Мэдээлэл дамжуулалт
- Ашиг хуваарилалт

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ БИЗНЕС ПРОЦЕСС



Тайлан, судалгаа



**МОНГОЛЫН
ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ
ЦОГЦ ХӨГЖЛИЙГ
ОЙЛГОХ НЬ**
Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Төр засгийн зүгээс бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар ихээхэн ахиц дэвшил гаргаж буй хэдий ч өсвөр залуу үеийнхэнд чиглэсэн үйл ажиллагаа дутагдалтай байгаа нь харагдаж байна.

Тодорхой бодлогын шийдвэр гаргах болон мэдээ, тайлан зэрэгт өсвөр насныхныг орхигдуулж байгаа явдал тэднийг үе дамжсан тэгш бус байдлын эргүүлэгт оруулж байна.

2019 он

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн судалгаа: 2021 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3.7, 2022 онд 5.4 хувийг (гэмт хэргийн тоо-1102) өсвөр насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. (2022 он)

ХЭРЭГЛЭЭНИЙ ШАТАНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ - СОЁЛЫН ЭРХИЙН БИЧИГ

Хүүхэд, залуучуудын соёлын хэрэглээг идэвхжүүлэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын салбарыг тэлэх, соёл хүртэх дадал зуршлыг бий болгох, урлагт чин сэтгэлээсээ татагдах байдлыг дэмжих

ЭРХИЙН БИЧИГ НЬ ЦАХИМ БҮРТГЭЛИЙГ АШИГЛАЖ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ЗОРИУЛАГДСАН ТОО ХЭМЖЭЭГ ИЛЭРХИЙЛСЭН ХЭРЭГСЭЛ

№	Он	Насны бүлгээр			Хүн ам	Санхүүжилт /мян.төг/
		16 нас	17 нас	18 нас		
1.	2024	54652	45742	42275	142669	14,266,900.00
2.	2025	61493	54652	45742	161887	16,188,700.00
3.	2026	67114	61493	54652	183259	18,325,900.00

Тайлбар: Үндэсний статистикийн хорооны 2023 оны жилийн эцсийн хүн амын мэдээг ашиглав.

Соёлын Эрхийн бичиг

Худалдан авах бүтээгдэхүүн

- Урлагийн тоглолт,
- Театр, кинотеатр, музей, үзэсгэлэн үзэх
- урлагийн сургалт -бүжиг, зураг, хөгжмийн сургалтад хамрагдах,
- видео тоглоом тоглох, дуун сонсох гэх мэт цахимаар үйлчилгээ авах
- ном худалдан авах

Санхүүжилтийн хэмжээ
Нэг жилд олгох-100 К

Хугацаа

3 жилийн турш :16 -18 нас

Санхүүжилтын хуваарилалт

Улсын төсөв


Хэрэгжүүлэх механизм

гар утасны аппликейшн болон цахим хуудас


Эргэх холбоо

Насны онцлогт тохирсон агуулга бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг холбох, агуулга, чанар, хэрэглээг хянах,

Соёл урлагийн үзвэр, үйлчилгээнд хамрагдаггүй шалтгаан



Хэрэгжүүлэх Механизм



Соёлын эрхийн бичиг –хэрэгжүүлэх механизм

Иргэн хүсэлт гаргах
-16 нас хүрмэгц

- регистрийн дугаар;
- эцэг/эхийн нэр;
- өөрийн нэр;
- имэйл хаяг;
- гар утасны дугаар.

Код илгээх

- Гар утас эсхүл мэйл хаягт нууц үг илгээх

Системд нэвтрэх
хүсэлт илгээх

- РД дугаар-мэдээлэл татах E-Mongolia

Хяналт,
баталгаажуулалт

- Эрх үүсэх,
- Цахим хэтэвч үүсэх

Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, төлөвлөлт

- Цаашдын чиг хандлага, үйл ажиллагааны төлөвлөлт
- Төсвийн төлөвлөлт

Тайлан,
мэдээлэх

- Хөтөлбөрийн жагсаалтыг эрэмбэлэх
- Ил тод мэдээлэх

Судалгаа

- Хэрэглэгчийн сэтгэл ханамж
- Хөтөлбөрийн үнэлгээ
- Хөтөлбөрийн жагсаалтыг эрэмбэлэх

Ашиглалт

- Төлбөргүй - шууд ашиглах
- Төлбөртэй-цахим хэтэвч ашиглах

Соёлын эрхийн бичиг –хэрэгжүүлэх механизм



СОЁЛЫН ЭРХИЙН БИЧИГ – ҮР НӨЛӨӨ



- Ирээдүйн “Соёл хүртэж сурсан иргэн”-ийг төлөвшүүлнэ.
- Иргэдийн соёл урлагийг сонирхох боломжийг нэмэгдүүлж, гоо зүйн болон урлагийн боловсрол олгон, анги, бүлгээр хамрагдснаар хамтач, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлнэ.
- ЕБС, Их, дээд сургуулийн сургалтын агуулгыг соёл урлагийн агуулгаар баяжуулна.
- Өсвөр насныхныг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэн, гэмт хэрэг, зөрчил, сөрөг нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Амжиргааны түвшингээс үл хамааран хүүхэд бүр соёл, урлагийн үйлчилгээ авах тэгш хүртээмжийг бүрдүүлнэ.
- Урлагийн боловсрол нь хүүхдийн зөв төлөвшлийг бий болгох, нийгмийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлнэ.
- Монголын соёлын үнэт зүйлс, соёлын өвийг танин мэдэх боломжийг олгоно.



- Хүүхдэд зориулсан урлагийн бүтээлийн санхүүжилт нэмэгдэнэ.
- Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, контент бүтээх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- Хэрэглээг нэмэгдүүлснээр, эдийн засгийн эргэлт, тогтвортой өсөлтийг дэмжинэ.
- Соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн олон улсад өрсөлдөх боломжийг нэмэгдүүлж, Монгол Улсыг сурталчлах нөхцөл бүрдэнэ.

- Дэд бүтцийн дэмжлэг үзүүлнэ (16 дугаар зүйл)



Төрийн өмчийг гэрээний үндсэн дээр ашиглуулах (15 дугаар зүйл)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төлөвлөлтийг хийх, (16.1) Зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг барих (16.2)

Дэд бүтцийг барих, түүнд хөрөнгө оруулалт хийхэд татварын дэмжлэг үзүүлэх. (16.5)

- Соёлын үнэт зүйлийн загварыг төлбөртэй ашиглуулах, арилжааны бус зорилгоор ашиглаж нөхцөлд таатай үнээр санал болгоно.


- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх (17 дугаар зүйл)



Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, дэд бүтэц, кластер байгуулахад дэмжлэг үзүүлэх; (17 дугаар зүйл)



Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих бүс тогтоох, **дэд бүтцийн хангамжийг сайжруулах;** (17.7)



- Дижитал хаб, (17.7, 17.7)

Бүс нутаг-Бүтээлч үйлдэрлэл

Экспортын хэтийн төлөв

Дотоодын хөрөнгө оруулалт, орон нутгийн чадавх

Жуулчид, зочдыг татах

Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх

Гадаадын хөрөнгө оруулалт, гарааны бизнес

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өсөлт

Бүтээлч иргэдийг шилжилт, татах

Уламжлалт үйлдвэрлэлд суурилсан бүтээгдэхүүн экспортыг нэмэгдүүлэх

Брэнд бүтээх

Бүтээлч үйлдвэрлэл-өрсөлдөх чадвар





Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэх – Бүртгэл мэдээллийн сан

(19 дүгээр зүйл)

Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг (20.2)

- Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч дараах эрх эдэлнэ:
- Энэ хууль, бусад хууль тогтоомжид заасан **дэмжлэг авах**;
үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлох, зах зээлийн үнээр борлуулах; холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, ашиглах, **дэд бүтцээр хангагдах**;
- **Оюуны өмчийн бүтээлээ ашиглах, үр шимийг хүртэх, оюуны өмчийн эрхээ хамгаалуулах**, эрхийн шимтгэлийн орлого авах;
- Мэдээллийн сангаас өөрт хамаарах **мэдээллээр хангагдах**, мэдээллээ шинэчлэх;

Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэг хүлээнэ: (20.3)

- Хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, дүгнэлт, **зөвлөмжийг биелүүлэх**;
- Шударгаар **өрсөлдөх**;
- Соёлын үйлдвэрлэлтэй холбоотой хэрэглэгчийн **үндсэн эрх, ашиг сонирхлыг хамгаалах**;
- Ажилтны мэдлэг, туршлага, мэргэжлийн **ур чадварыг дээшлүүлэх**;
- Энэ хуулийн дагуу авсан дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын явц, үр дүнг холбогдох эрх бүхий этгээдэд **тайлагнах**;
- Мэдээллийн санд **холбогдох мэдээллийг хүргүүлэх**.

Засгийн газар (соёлын бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын дотоодын зах зээлийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, орчин үеийн технологи нэвтрүүлэх таатай орчныг бий болгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих үндэсний зөвлөл байгуулах, ажиллах журмыг батлах) (21 дүгээр зүйл)

- **Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага: (соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, салбар хоорондын уялдааг хангах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн болон үндсэн чиглэлийн хүрээнд суурь судалгаа хийх арга хэмжээг зохион байгуулах) (22 дугаар зүйл)**
- **Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал: соёлын бүтээлч үйлдвэрлэлийн барилга байгууламжийн төлөвлөлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг хангуулах, харьяалах нутаг дэвсгэртээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүнийг дэмжих бодлого, арга хэмжээг батлах) (24 дүгээр зүйл)**
- **Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга (харьяалах нутаг дэвсгэртээ соёлын бүтээлч үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүнийг бий болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах) (25, 26 дугаар зүйл)**



ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дахь тайлагнал, ил тод байдал:

Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, хөрөнгө оруулагч, хамтын удирдлагын байгууллага нь авсан дэмжлэг, үйл ажиллагааны тухайн жилийн тайлангаа дараа жилийн 1 дүгээр улиралд тайлагнаж байна. (28.1)

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх тайланг Засгийн газарт танилцуулна. (28.2)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дахь дэмжлэгийг ил тод мэдээлнэ. (28.4)





Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль
Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай
Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай
Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай

ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ



- Аж ахуйн нэгжийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор өгсөн албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцоно. (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай)
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн үндсэн үйл ажиллагаанд ногдох орлогын албан татварыг эрх бүхий байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах эхний 3 жилд 90 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай)
- соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, дэд бүтэц, үйлдвэр барих зориулалтаар импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг хөнгөлж, чөлөөлөх асуудлыг зохицуулна. (Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай – 11.2.2)
- Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэлийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль батлагдсанаас хойш 5 жилийн хугацаанд нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх шаардлагатай.



СОЁЛЫН ЯАМ

АНХААРЛАА ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА